



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 26 өдөр

Дугаар А/108

Хэрлэн сум

Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн
бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.13, 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.18 дахь заалт, Засгийн газрын 2024 оны 62 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Зудын гамшигтай тэмцэх хариу арга хэмжээг хэрэгжүүлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, иргэн, хуулийн этгээдийг 2024 оны 2 дугаар сарын 21-ний өдрийн 06:00 цагаас 2024 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн 06:00 цаг хүртэлх хугацаанд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсүгэй.

2.Аймаг, сумдын Засаг даргын тамгын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсанаас бусад соёл, урлаг, олон нийтийн арга хэмжээг 2024 оны 5 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд хориглосугай.

3.Гамшгийн нөөцийг аймгийн хэмжээнд нэмэгдүүлэх, стратегийн хүнс, бараа, бүтээгдэхүүний хомсдол, үнийн хөөргөдөл, эмнэлгийн анхан шатны болон сэтгэл заслын тусламж үзүүлэх болон нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүсэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох мэргэжлийн байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

4.Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд Улсын онцгой комиссын шуурхай штабт мэдээ мэдээллийг дамжуулан удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга (Ж.Энх-Амгалан), Эрүүл мэндийн газрын дарга (Л.Мэндбаяр), Мал эмнэлгийн газрын дарга (Н.Анхбаяр), Цагдаагийн газрын дарга (цагдаагийн дэд хурандаа Э.Жавхлантөгс), Онцгой байдлын газрын дарга (хурандаа Ж.Эрдэнэбат) нарт тус тус даалгасугай.

2.


5.Бусад аймаг, сумдаас отор нүүдлээр орж ирсэн малчин өрхүүдэд бүх төрлийн төрийн үйлчилгээг хүртээмжтэй хүргэж ажиллахыг Эрүүл мэндийн газрын дарга (Л.Мэндбаяр), Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга (С.Мөнхцэцэг), Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга (Х.Уртнасан), бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.

6.Аймгийн хэмжээнд цаг агаарын урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, цасны хэмжилтийн мэдээллийг сумдын онцгой комиссын шуурхай штаб болон малчид, иргэдэд тухай бүр шуурхай хүргэж ажиллахыг Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн дарга (Б.Хэрлэнчимэг)-т үүрэг болгосугай.

7.Бүх шатны төрийн байгууллага, хуулийн этгээдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Онцгой байдлын газрын дарга (хурандаа Ж.Эрдэнэбат)-д үүрэг болгосугай.

8.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ